



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/171

Сүхбаатар сум

Улсын тооллогоор илэрсэн зөрчлийг арилгаж,
хариуцлага тооцох арга хэмжээг авч ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а" Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.4, 26 дугаар зүйлийн 26.2 дэх заалт, Засгийн газрын 2С18 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгал зүйлийн улсын тооллого хийх журам"-ын 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 төсөт тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ аймгийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын ажлын явцад гарсан зөрчил, дутагдсан, солигдсон үзмэрийг хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж, буруутай этгээдийг тогтоон, хариуцлага тооцож, байгууллагыг хохиролгүй болгон ажиллахыг аймгийн Нэгдсэн музейн захирал /Л.Бямбаа/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын ажлын дүнг үндэслэн цаашид аймгийн Нэгдсэн музей, сумдын орон нутаг сурталчлах танхимын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, сумдын Засаг дарга, аймгийн Нэгдсэн музейн захирал нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.СРГИЛ